



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.25 № 34
танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.САРУУЛЖАРГАЛ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад цалингийн зардал өмнөх оноос 108.5 сая төгрөг өссөн нь Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой байна. Мөн авлага 143.2 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилтийн авлага байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төв нь сумын Засаг даргатай

4825020114

байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилт, 36 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг ханган ажилласнаар 94.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	194,717,810.16	349,673,314.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,643,984.77	77,666,308.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,643,984.77	77,666,308.30
3121	Төгрөг	63,643,984.77	77,666,308.30
31211	Төрийн сангийн харилцах	55,560,884.77	77,583,208.30
31218	Ахмадын сангийн харилцах	8,083,100.00	83,100.00
33	АВЛАГА	5,876,174.00	149,021,622.16
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,876,174.00	149,021,622.16
35	БАРАА МАТЕРИАЛ	125,197,651.39	122,985,383.75
351	Түүхий эд материал	108,357,985.39	94,410,421.85
35110	Тусгай зориулалттай материал	34,108,913.94	34,723,062.83
35130	Эм боох материал	74,249,071.45	59,687,359.02
354	Хангамжийн материал	16,839,666.00	28,574,961.90
35410	Бичиг хэргийн материал	855,500.00	5,533,570.00
35420	Аж ахуйн материал	11,890,736.00	20,902,147.50
35440	Түлш, шатах тослох материал	1,507,000.00	720,810.00
35460	Хүнсний материал	2,586,430.00	1,418,434.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,285,032,768.16	1,292,367,325.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,285,032,768.16	1,292,367,325.29
392	Биет хөрөнгө	1,273,966,768.16	1,281,481,325.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	976,891,644.59	956,761,793.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(102,500,986.10)	(95,144,179.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,990,000.00	65,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,246,166.59)	(26,244,166.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	226,374,696.85	267,873,838.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(79,553,523.85)	(110,116,093.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,148,231.00	35,295,456.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,137,127.74)	(12,935,324.09)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	200,000,000.00	200,000,000.00
393	Биет бус хөрөнгө	11,066,000.00	10,886,000.00
39301	Програм хангамж	360,000.00	360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(180,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,706,000.00	10,706,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,479,750,578.32	1,642,040,639.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,470,842.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,470,842.00	-
413	Өглөг	2,470,842.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,470,842.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,477,279,736.32	1,642,040,639.50
51	Засгийн газрын хувь оролцоо	1,477,279,736.32	1,642,040,639.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	334,600,425.76	334,600,425.76
51101	Өмч: - төрийн	334,600,425.76	334,600,425.76
512	Хуримтлагдсан үр дүн	1,092,230,996.09	1,256,991,899.27
51210	Өмнөх үеийн үр дүн	1,145,485,143.21	1,092,230,996.09
51220	Тайлант үеийн үр дүн	(53,254,147.12)	164,760,903.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,448,314.47	50,448,314.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,479,750,578.32	1,642,040,639.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	607,320,588.84	969,840,002.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,213,813.42	127,426,034.93
120	Нийтлэг татварын бус орлого	58,213,813.42	127,426,034.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,800.00	29,127,278.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,800.00	29,127,278.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	32,049,394.20	74,124,567.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	26,018,619.22	24,174,189.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	549,106,775.42	842,413,967.25
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,565,600.00	46,102,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,565,600.00	46,102,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	510,541,175.42	796,311,067.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	510,541,175.42	796,311,067.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	645,390,289.73	801,693,786.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645,390,289.73	801,693,786.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,941,240.46	778,707,521.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,239,111.00	429,706,182.00
210101	Үндсэн цалин	215,313,218.00	261,264,705.00
210102	Нэмэгдэл	73,577,462.00	128,522,007.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,834,000.00	3,499,000.00
210104	Урамшуулал	28,514,431.00	36,420,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,657,936.00	55,843,203.06
210201	Тэтгэврийн даатгал	27,866,326.69	37,871,425.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,278,391.39	4,441,533.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,569,909.30	2,728,545.83
210204	Ажилгүйдлийн даатгал	631,208.92	2,154,768.20
210205	Эрүүл мэндийн даатгал	6,312,099.70	8,646,929.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,412,192.73	38,223,792.85
210301	Гэрэл, цахилгаан	1,885,743.73	2,094,887.85
210302	Түлш, халаалт	30,336,449.00	33,630,905.00
210303	Цэвэр, бохир ус	1,190,000.00	2,498,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,574,989.00	53,982,969.60
210401	Бичиг хэрэг	3,208,700.00	4,029,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,465,950.00	23,714,453.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,087,800.00	1,877,800.00
210404	Ном, хэвлэл	83,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,568,325.00	1,298,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,965,050.00	11,174,864.70
210408	Бараа материал акталсны зардал	10,196,164.00	11,887,831.40
2105	Нормативт зардал	92,557,544.77	81,925,071.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,673,959.77	66,498,710.47
210502	Хоол, хүнс	7,964,685.00	10,795,360.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,918,900.00	4,631,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,448,592.75	5,056,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,185,892.75	-
210604	Урсгал засвар	7,262,700.00	5,056,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,237,000.00	5,150,000.00
210702	Дотоод албан томилолт	6,237,000.00	5,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,261,215.60	6,240,405.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,056,000.00	1,893,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	142,350.00	258,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,805.60	104,156.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	770,000.00	1,335,000.00
210807	Газрын төлбөр	107,060.00	101,119.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	374,000.00	787,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,552,658.61	102,579,898.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,698,510.00	20,186,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,854,148.61	82,393,698.26

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	449,049.27	22,986,265.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	22,578,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,578,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	449,049.27	408,265.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	449,049.27	408,265.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(38,069,700.89)	168,146,215.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,184,446.23	3,385,312.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,184,446.23	3,385,312.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,184,446.23)	(3,385,312.01)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(53,254,147.12)	164,760,903.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>551,376,401.42</u>	<u>728,395,797.09</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,145,800.00	29,127,278.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,145,800.00	29,127,278.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,145,800.00	29,127,278.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,145,800.00	29,127,278.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	543,230,601.42	699,268,519.09
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,565,600.00	46,102,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,565,600.00	46,102,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	504,665,001.42	653,165,619.09
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	504,665,001.42	653,165,619.09
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>522,092,311.60</u>	<u>695,384,473.56</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	522,092,311.60	695,384,473.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,643,262.33	672,398,208.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	329,239,111.00	429,706,182.00
210101	Үндсэн цалин	223,313,218.00	261,264,705.00
210102	Нэмэгдэл	73,577,462.00	128,522,007.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,834,000.00	3,499,000.00
210104	Урамшуулал	28,514,431.00	36,420,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,657,936.00	55,843,203.06
210201	Тэтгэврийн даатгал	27,866,326.69	37,871,425.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,278,391.39	4,441,533.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,569,909.30	2,728,545.83
210204	Ажилгүйдлийн даатгал	631,208.92	2,154,768.20
210205	Эрүүл мэндийн даатгал	6,312,099.70	8,646,929.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,941,350.73	40,694,634.85
210301	Гэрэл, цахилгаан	1,885,743.73	2,094,887.85
210302	Түлш, халаалт	27,865,607.00	36,101,747.00
210303	Цэвэр, бохир ус	1,190,000.00	2,498,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,650,300.00	42,110,363.50
210401	Бичиг хэрэг	3,692,700.00	7,495,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,976,950.00	22,707,463.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,087,800.00	1,877,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,290,000.00	1,907,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,602,850.00	8,122,500.00
2105	Нормативт зардал	60,119,989.00	61,539,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,191,439.00	48,418,065.00
210502	Хоол, хүнс	7,759,650.00	7,831,075.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	168,900.00	5,290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,840,700.00	9,715,910.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	578,000.00	-
210604	Урсгал засвар	7,262,700.00	9,715,910.00
2107	Томилолт, зочны зардал	6,237,000.00	5,150,000.00
210702	Дотоод албан томилолт	6,237,000.00	5,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,408,215.60	7,452,575.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,056,000.00	1,893,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	142,350.00	258,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,805.60	104,156.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	770,000.00	1,335,000.00
210807	Газрын төлбөр	107,060.00	101,119.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	521,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,548,660.00	20,186,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,548,660.00	20,186,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	449,049.27	22,986,265.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	22,578,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	22,578,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	449,049.27	408,265.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	449,049.27	408,265.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>29,284,089.82</u>	<u>33,011,323.53</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,850,000.00	18,989,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,850,000.00	18,989,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,850,000.00	18,989,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,850,000.00	18,989,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,850,000.00)</u>	<u>(18,989,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	26,434,089.82	14,022,323.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,209,894.95	63,643,984.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,643,984.77	77,666,308.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,145,485,143.21	1,530,533,883.44
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,145,485,143.21	1,530,533,883.44
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-53,254,147.12	-53,254,147.12
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,092,230,996.09	1,477,279,736.32
5	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,092,230,996.09	1,477,279,736.32
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,092,230,996.09	1,477,279,736.32
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	164,760,903.18	164,760,903.18
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,600,425.76	50,448,314.47	1,256,991,899.27	1,642,040,639.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Ан ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	879,759,700.00	705,965,208.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879,759,700.00	705,965,208.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,181,700.00	683,387,208.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,330,000.00	429,706,182.00
210101	Үндсэн цалин	295,000,000.00	261,264,705.00
210102	Нэмэгдэл	168,000,000.00	128,522,007.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,780,000.00	3,499,000.00
210104	Урамшуулал	54,550,000.00	36,420,470.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,416,400.00	55,843,203.06
210201	Тэтгэврийн даатгал	45,843,100.00	37,871,425.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,393,300.00	4,441,533.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,696,700.00	2,728,545.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,696,700.00	2,154,768.20
210205	Эрүүл мэндийн даатгал	10,786,600.00	8,646,929.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,102,900.00	40,694,634.85
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,094,887.85
210302	Түлш, халаалт	36,102,900.00	36,101,747.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,498,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,533,300.00	42,110,363.50
210401	Бичиг хэрэг	7,520,100.00	7,495,100.00
210402	Тээвэр, шатахуун	22,709,300.00	22,707,463.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,937,800.00	1,877,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,406,000.00	1,991,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,960,100.00	8,038,500.00
2105	Нормативт зардал	91,651,300.00	61,539,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,820,900.00	48,418,065.00
210502	Хоол, хүнс	8,830,400.00	7,831,075.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00	5,290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,650,000.00	28,704,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	18,989,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	16,150,000.00	9,715,910.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	5,150,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	5,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,872,500.00	7,452,575.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,647,800.00	1,893,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,728,000.00	1,728,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	258,300.00	258,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,200.00	104,156.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	1,335,000.00
210807	Газрын төлбөр	101,200.00	101,119.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,625,300.00	12,186,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,625,300.00	12,186,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,578,000.00	22,578,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,578,000.00	22,578,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,578,000.00	22,578,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	879,759,700.00	727,987,531.94
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,102,900.00	45,694,634.85
122005	Орон нутгийн төсвөөс	46,102,900.00	45,694,634.85
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	749,708,600.00	653,165,619.09

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	749,708,600.00	653,165,619.09
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	83,948,200.00	29,127,278.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,387,300.00	29,127,278.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	55,560,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	55,560,884.77
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	77,583,208.30

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 37,159.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 22,467.2 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 14,692.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 14,692.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, зөрчил арилгах зөвлөмжийг хүргүүллээ.

3.1 Зөвлөмж

3.1.1. Бараа материал данстай холбоотой.

Илрүүлэлт:

Эм ороох боох материалын дансанд эмнэлгийн тусгай зориулалтын багаж, аж ахуйн материал хэрэгслийг бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д: "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" заасныг мөн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын эдийн засгийн ангиллыг үнэн зөв бүртгэж, санхүүгийн тайланд залруулга хийн, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх.

3.1.2. Бараа материал данстай холбоотой.

Илрүүлэлт:

Аж ахуйн материал, тусгай зориулалтын материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заасныг мөн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг эдийн засгийн ангиллын дагуу үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх

3.1.3 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой.

Илрүүлэлт:

Хангамжийн материалын зардлаас нормативт зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасныг, мөн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалт хийж тайлагнах, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх

3.1.4 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой.

Байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлогыг журамд заасан хугацаанаас хоцроон төрийн сангийн харилцах дансанд тушаасан. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дугээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6.10-г *"Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг ишүүд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журам"* заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллах журмыг мөрдөж ажиллах, хариуг нотлох баримтын хамт Дундговь аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг үнэ тогтоож үнэ төлбөргүй орлогоор бүртгэхдээ тодруулга тайланд дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан.	1	22,467.2					1	22,467.2				
Дүн	1	22,467.2					1	22,467.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Эм ороох боох материалын дансанд эмнэлгийн тусгай зориулалтын багаж, аж ахуйн материал хэрэгслийг бүртгэж тайлагнасан.	1	12,377.8						1	12,377.8		
Аж ахуйн материал, тусгай зориулалтын материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан.	1	470.9						1	470.9		
Хангамжийн материалын зардлаас нормативт зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчсөн	1	1,104.0						1	1,104.0		
Байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлогыг журамд заасан хугацаанаас хоцроон төрийн сангийн харилцах дансанд тушаасан.	1	740.0						1	740.0		
Дүн	4	14,692.7						4	14,692.7	-	-

5.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			